2017 оны 10 сарын 29-с 11 сарын 4-ний өдрүүдэд зохион багуулагдсан Даамны өсвөрийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцсон 97-р сургуулийн суранч П.Эрдэнэбилэг үндсэн тавилд хүрэл медаль хүртлээ. Тэмцээний Турк даамны төрөлд Шавь цогцолбор сургуулийн Б.Энхрийлэн алт, Б.Анужин алт, 84-р сургуулийн Б.Мишээл мөнгө, 14-р сургуулийн С.Болор алт,

Шинэ монгол сургуулийн Б.Баярмагнай мөнгө нийт: алт-3, мөнгө-2, хүрэл-2 медаль хүртлээ.



## 2. Нийтийн биеийн тамир

### ➤ Уралдаан тэмцээн

#### “Мөнгөн улаанбаатар-2017”- өвлийн өдөрлөг

"Мөнгөн Улаанбаатар" өвлийн арга хэмжээ дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудын ажилтан албан хаагчдын дунд 2017 оны 02 дугаар сарын 04-ны өдөр "Хүй долоо худагт" зохион байгуулагдаж, Тус арга хэмжээнд БЗД-ийн Хөдөлмөр эрхлэлт, хөгжлийн асуудал хариуцсан Засаг даргын орлогч Т. Баясах, Засаг Даргын Тамгын газрын дарга Б. Амартүвшин, Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга С.Сувд-Эрдэнэ, Биеийн тамир спорт хорооны дарга С. Эрдэнэбат болон бусад төлөөлөгчид оролцлоо. Цасны баярт 21 байгууллагын 460 гаруй ажилтан албан хаагчид хамрагдаж, Спортын гурван төрлөөр өрсөлдсөнөөс:

#### Цасны сумо

**Эмэгтэй** 1-р байр Сүнжидмаа /НҮГ/

**Эрэгтэй** 1-р байр Лхагважав /Цагдаа 3 хэлтэс/

2-р байр Мөнхтуяа /Дүүрэг хөгжлийн төв/ 2-р байр Баттулга /Цагдаа 3 хэлтэс/

3-р байр Мөнхбилэг /ЗДТГ/

3-р байр Батжавхлан /ЗДТГ/

#### Гир өргөлт

**Эмэгтэй** 1-р байр Сүнжидмаа

**Эрэгтэй** 1-р байр Сүхбаатар /ОБХ/

2-р байр Өлзий-Отгон /ЗДТГ/

2-р байр Лхагважав /Цагдаа 3 хэлтэс/

3-р байр Амартүвшин /ЗДТГ/

3-р байр Баттулга /Цагдаа 3 хэлтэс/

#### Олс таталт

1-р байр Засаг даргын тамгын газар

2-р байр Цагдаа 1 хэлтэс

3-р байр НҮГ

4-р байр Онцгой байдлын

хэлтэс тус тус шалгарч өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдлаа.

Мөн Биеийн тамир, спортын хорооны ажилтан, албан хаагчид болон өсвөрийн шигшээ багийн тамирчдын дунд спортын 3 төрлөөр тэмцээн зохион байгуулж эхний 3

байр эзэлсэн тамирчдыг  
байгууллагын шагналаар шагнаж  
урамшууллаа.



### Баянзүрх дүүргийн “Цэвэр агаар-идэвхтэй хөдөлгөөн-2017” өвлийн арга хэмжээ.

Баянзүрх дүүргийн ерөнхий боловсролын сургуулиуд , цэцэрлэг, хороодод байгууллагынхаа ажилтан албан хаагчдын дунд “Цэвэр агаар-идэвхтэй хөдөлгөөн” -2017 сэдэвт өвлийн арга хэмжээг зохион байгуулах талаар Биеийн тамир спортын хорооны даргын албан бичиг, зөвлөмж, удирдамжыг хүргүүлэн ажиллаа. Удирдамжын дагуу 15 байгууллагын 800 гаруй албан хаагчид



өвлийн арга хэмжээ, цасны баярт оролцож тайлан мэдээгээ ирүүлээд байна.

Байгуулагууд ажилтан, албан хаагчдынхаа дунд олон төрлийн тэмцээн



зохион байгууллаа.

### Хонхтой бөмөгийн аварга шалгаруулах тэмцээн

Дүүргийн хүн амын эрүүл мэндийг бэхжүүлж хамгаалах, нийтийн биеийн тамир спортын арга хэмжээнд өргөнөөр хамруулах ажлын хүрээнд хараагүй иргэдийн дунд хонхтой бөмбөгийн тэмцээнийг жил бүр явуулж тэднийг хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх, сэтгэл санаа бие бялдарыг нь сэргээн баг тамирчдын ур чадвар туршлагыг нэмэгдүүлэх зорилгоор хонхтой бөмбөгийн тэмцээнийг амжилттай





зохион байгууллаа.

Хонхтой бөмбөгийн тэмцээн 2017 оны 03 дугаар сарын 27-ны өдөр Монголын Хараагүйчүүдийн үндэсний холбооны зааланд амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. Тэмцээнд эмэгтэй эрэгтэй 10 багийн 50 гаруй тамирчид оролцлоо.

Тэмцээний ерөнхий шүүгчээр БЗД-ийн Биеийн тамир спорт хорооны мэргэжилтэн С.Сувд, талбайн шүүгчээр Хонхтой бөмбөгийн холбооны нарийн бичгийн дарга П.Туул, Н.Анхбаяр, нарийн бичиг шүүгч О.Цэвэлмаа, шугамын шүүгчээр Б.Ганбат, Ж.Лхагваэрдэнэ, Сүхбаатар, Ц.Уранчимэг, Б.Гантулга, О.Түмэнжаргал нар шүүн явууллаа.

Тэмцээний эхний 3 байр:

Эрэгтэй: 1-р Монголын Хараагүйчүүдийн үндэсний холбоо  
2-р Баянзүрх дүүрэг  
3-р Хан-Уул дүүрэг

Эмэгтэй: 1-р Баянзүрх дүүрэг  
2-р Хан-Уул дүүрэг

3-р Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв шалгарч алт, мөнгө, хүрэл медаль, өргөмжлөл мөнгөн шагналаар шагнууллаа.

### **Цэцэрлэгийн хүүхдийн уран хөдөлгөөнт гимнастикийн тэмцээн**

Дүүргийн цэцэрлэгүүдийн дунд жил болгон уламжлал болгон зохион байгуулагддаг уран хөдөлдгөөнт гимнастикийн аварга шалгаруулах тэмцээн 2017 оны 04 дүгээр сарын 05-нд Алдар спорт хорооны спорт зааланд амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө.



Тэмцээнд нийтдээ 16 цэцэрлэгийн 480 гаруй хүүхэд оролцож, 400 гаруй хөгжөөн дэмжигчидтэй оролцлоо. Тэмцээний нээлтэнд Баянзүрх дүүргийн Биеийн тамир спорт хорооны дарга С.Эрдэнэбат, Боловсролын хэлтэсийн дарга Х.Батбаяр, сургуулийн өмнөх боловсрол хариуцсан мэргэжилтэн Энхтуяа цэцэрлэгийн эрхлэгч арга зүйчид тэмцээнд оролцож буй бяцхан тамирчдад амжилт хүсч баяр хүргэлээ.



Тэмцээний шүүгчээр Нийслэлийн Биеийн тамир спортын газрын ахлах мэргэжилтэн Улсын шүүгч А.Болдмаа, Улсын шүүгч Ж.Чулуунцэцэг, Т.Цэрэндулам, Б.Ууганбаяр, С.Сувд нар шүүн явууллаа.

- 1-р байр 61 дүгээр цэцэрлэг
- 2-р байр 147 дүгээр цэцэрлэг
- 3-р байр 129 дугаар цэцэрлэг
- Тусгай байр 32-р цэцэрлэг

Тусгай байр 82-р цэцэрлэг шалгарч өргөмжлөл, медалийн эзэд болж 61 дүгээр цэцэрлэг шилжин явах цомын эзэн боллоо. Тэмцээнд амжилттай оролцсон хүүхэд бүрт батламж гардуулан өглөө.

Эхний 3 байранд шалгарсан 61 дүгээр цэцэрлэг, 147 дугаар цэцэрлэг, 129 дүгээр цэцэрлэг, нийслэлийн цэцэрлэгийн уран хөдөлгөөнт гимнастикийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрхээ авлаа. Цэцэрлэгийн уран хөдөлгөөнт гимнастикийн тэмцээний үеэр Сүлд ТВ ирж бичлэг хийлээ.

### **ЕБС-ийн сурагчдын уран хөдөлгөөнт Гимнастикийн тэмцээн**

Монгол Улсын “Биеийн тамир, спортын тухай” хууль, Засгийн газрын 05, 34 дүгээр тогтоолууд, Нийслэл, дүүргийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, өсвөр үеийнхний эрүүл мэндийг бэхжүүлж, бие бялдрыг гимнастикийн дасгал хөдөлгөөнөөр чийрэгжүүлэх, тэднийг биеийн тамир, спортын үйл ажиллагаанд татан оролцуулах зорилгоор Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг уран хөдөлгөөнт гимнастикийн тэмцээн 2017 оны 04-р сарын 16-ны өдөр 53 дугаар сургуулийн спорт зааланд амжилттай болж өндөрлөө.

Тэмцээнд бага, дунд, ахлах гэсэн 3 насны ангилалд 9 сургуулийн 284 тамирчин сурагчид оролцлоо.

Тэмцээний ерөнхий шүүгчээр Монголын гимнастикийн холбооны зөвлөх багш, Олон улсын шүүгч Ц.Марта, Нийслэлийн Нийтийн биеийн тамирын спортын хорооны ахлах мэргэжилтэн А.Болдмаа нарийн бичиг шүүгчээр Улсын шүүгч Ж.Чулуунцэцэг, Б.Ууганбаяр, Э.Мөнхоргол, С.Сувд нар шүүн явууллаа



Бага насны ангилалд: 1-р байранд Баянзүрх цогцолбор сургууль  
2-р байранд 53 дугаар сургууль  
3-р байранд Улаанбаатар сургууль

Дунд насны ангилалд : 1-р байранд Баянзүрх цогцолбор сургууль  
2-р байранд 84 дүгээр сургууль 2-р баг  
3-р байранд 84 дүгээр сургууль 1-р баг

Ахлах насны ангилалд: 1-р байранд 84 дүгээр сургууль  
2-р байранд 53 дугаар сургууль  
3-р байранд Баянзүрх цогцолбор сургууль

Багийн нийлбэр дүнгээр: 1-р байранд Баянзүрх цогцолбор сургууль  
2-р байранд 84 дүгээр сургууль  
3-р байранд 53 дугаар сургуулиуд эхний 3 байр эзэлж өргөмжлөл, медалиар шагнагдаж Баянзүрх цогцолбор сургууль шилжин явах цомын эзэн боллоо.

### **“БАГАХАНГАЙ МАРАФОН-2017” ӨСВӨР ҮЕ, НАСАНД ХҮРЭГЧДИЙН УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН**

“Багахангай марафон-2017” өсвөр үе, насанд хүрэгчидийн улсын аварга шалгаруулах тэмцээн 2017оны 06 сарын 11-нд Багахангай дүүрэгт амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. Тэмцээнд хот, хөдөө, дүүргийн 40 гаруй байгууллагаас Баянзүрх дүүрэг багийн дүнгээр **IV-р байр** эзэлсэн амжилттай оролцлоо. 20-с дээш насны ангилалд:

50км Хэт холын зайн гүйлтэнд: Б.Сүрэнжав мөнгөн медаль,  
35-с дээш насны ангилалд: 5 x10км эрэгтэй буухиа гүйлтэнд: Х.Энхболд, Ж.Дорж,  
Б.Нэргүй, Ш.Батсүх, Г.Цэрэндагва нарын бүрэлдхүүнтэй баг мөнгөн медаль

5 x10км эмэгтэй бүүхиа гүйлтэнд: Ч.Хэрлэнчимэг, Нина, Ж.Батчимэг,  
Мөнхбаяр нарын бүрэлдхүүнтэй баг мөнгөн медаль тус тус авсан амжилттайгаар тэмцээнээ дуусаглаа.





## “ДАНШИГ НААДАМ –ХҮРЭЭ ЦАМ” ШАШИН СОЁЛЫН НААДАМ-2017

“Даншиг наадам –хүрээ цам” шашин соёлын наадам-2017 оны 08дугаар сарын 05-06нд төв цэнгэлдэх хүрээлэнд ёслол төгөлдөр болж өндөрлөлөө. Уг наадамд Баянзүрх



дүүргийн биеийн тамир спорт хорооны дарга С.Эрдэнэбат хөлийн цэцээр зүлэг ногоон дэвжээнээ 2 өдрийн турш ажиллаж нийтийн биеийн тамрын мэргэжилтэн Э.Уянга үйлчилгээний ажил хийн ажиллаа.

## Өөрийгөө ялан дийлэх 12 & 24 гүйлтийн Улсын аварга шалгаруулах тэмцээн

Өөрийгөө ялан дийлэх 12&24 цагийн гүйлтийн улсын аварга шалгаруулах тэмцээн 2017оны 08 сарын 19-20нд үндэсний цэцэрлэгт хүрээлэнд амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. Тэмцээнд Баянзүрх дүүргийн ахмад мастеруудын холбооноос Д.Баатархүү (СМ ) , М. Батсүх (ОУХМ) дасгалжуулагчтай 16 тамирчин оролцож.

Р.Батэрдэнэ алт  
Ц.Алтансувд алт  
Г.Нарантуяа мөнгө  
Т.Бадамгарав мөнгө  
Р.Эрдэнэзоргил мөнгө  
Л.Цэцэгдэлгэр мөнгө  
Л.Батмөнх мөнгө  
М.Эрдэнэчимэг хүрэл  
З.Цэрэндагва хүрэл

С.Тунгалаг хүрэл медаль тус тус авж 2 алт 5 мөнгө 3 хүрэл медалийн амжилт үзүүллээ.



### **“ҮЗЭСГЭЛЭНТ УЛААНБААТАР-2017” олон улсын өртөөт марафон**

Нийслэлийн засаг даргын 2017 оны 08 дугаар сар 02-ны өдрийн А/578 дугаар захирамжын дагуу дүүргийн засаг даргын 2017 оны 08 дугаар сарын 09-ны А/748 дугаар захирамж, удирдамж гаргуулан 28 хороод ,дүүргийн харъяа, хэлтэс, албадад тэмцээний удирдамжыг тараасан. Мөн биеийн тамир спортын хороо нь Спорт хороо Баянзүрх FACEBOOK хаягаар тэмцээний мэдээллийг хүргэж байсан. “Үзэсгэлэнт Улаанбаатар -2017” өртөөт марафон 2017 оны 8 сарын 13-нд Сүхбаатарын талбайд амжилттай зохион байгуулагдсан. Баянзүрх дүүргийн биеийн тамир спорт хороо, Ахмад мастеруудын холбоотой хамтран 30 тамирчин оролцууллаа.

- Сэтгэлд хоногшисон Улаанбаатар төрөлд 6 баг
- Гэр Бүл төрөлд 2 баг

- Жуулчин төрөлд 1 баг Найзууд төрөлд 1 баг оролцсон ба Сэтгэлд хоногшисон Улаанбаатар төрөлд тэргүүн байр эзэлж цом, гадаадад аялах



эрхээр шагнуулсан.

## МОНГОЛЫН СПОРТ ЯВГАН АЯЛАЛЫН ХОЛБООНООС ЗОХИОН БАЙГУУЛСАН АХМАДЫН СПОРТ ЯВГАН АЯЛАЛЫН ТЭМЦЭЭНИЙ ТАЙЛАН

Монголын спорт явган аялалын холбооноос зохион байгуулсан ахмадын спорт явган

аялалын тэмцээн 2017 оны 09 сарын 25-29нд Дархан-уул аймагт амжилттай зохиогдож өндөрлөлөө. Тус тэмцээн Дархан-Орхоны хавцал маршрутаар 23км газар явган алхаж чамгүй шандас шаардсан тэмцээн болж өнгөрлөө. Тэмцээнд Баянзүрх дүүргийн биеийн тамир спорт хорооны дэргэдэх “Дэвжих” клуб Ц.Отгонсүрэн дасгалжуулагчтай Урагшаа, Хүмүүнлэг, Түүчээ гэсэн 3 баг оролцсоноос Урагшаа баг онооны дүнгээр 5-р байрт орсон ба Буухиа тэмцээнд 1-байр Түүчээ баг 6-р байр Хүмүүнлэг баг 8-р байрт орж нийлбэр дүнгээр 1-р байрт орж алтан медаль мөн Ц.Отгосүрэн шилдэг дасгалжуулагчаар шалгарж алтан медаль өргөмжиллөлөөр шагнуулав.



### “Хариу нэхээгүй тус” тэмцээний тайлан

Баянзүрх дүүргийн нийгмийн хөгжлийн хэлтэс, Биеийн тамир спортын хороо, 55-р тусгай сургууль хамтран хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын дунд "Хариу нэхээгүй тус" сэдэвт “хөгжөөнт буухиа” тэмцээнийг 2017 оны 11 сарын 22-нд 55-р тусгай сургууль дээр амжилттай зохион байгууллаа. Тэмцээнд 55-р сургуулийн 3-5 ангийн 12 бүлгийн 72 сурагч хамрагдсанаас:

1. Байрт -5а анги
2. Байрт -5в анги
3. Байрт -4в анги тут тус амжилттай оролцлоо.



Тэмцээний нээлтэнд НХХ-н дарга С.Сувд-Эрдэнэ хүрэлцэн ирж үг хэлэхдээ тэмцээнд оролцож байгаа нийт сурагчид болон багш, эцэг эхчүүдэд баяр хүргэж



амжилт хүслээ.

Тэмцээний эхний байр эзэлсэн багуудад НХХ-н Эрүүл мэнд, нийтийн биеийн тамир хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Болор-Эрдэнэ, Хүүхэд залуучууд гэр бүл хариуцсан мэргэжилтэн Ш.Ганцэцэг нар өргөмжлөл медаль гардуулсан ба нийт оролцсон хүүхдүүдэд гарын бэлэг гардууллаа.

### **Баянзүрх дүүргийн санхүүчдын аварга шалгаруулах тэмцээн**

Монгол Улсад Санхүүгийн алба үүсч байгуулагдсаны **106** жилийн ойн нэрэмжит Баянзүрх дүүргийн Санхүү бүртгэлийн ажилчдын дунд зохион явагддаг тэмцээн тус Сагсан бөмбөг, Волейбол, Дартс, Ширээний теннис 4 төрлөөр 7 багийн нийт 150 санхүүчид, ажилчид оролцож амжилттай зохион байгуулагдаж өндөрллөө.

Шагналт байранд:

#### **Сагсан бөмбөг**

- 1-р байр** Улаанхуаран
- 2-р байр** Төрийн сан
- 3-р байр** Хонхор
- 4-р байр** Шархад

#### **Волейбол**

- 1-р байр** Төрийн сан
- 2-р байр** Төв
- 3-р байр** Улаанхуаран
- 4-р байр** Сансар

#### **Дартс**

- 1-р байр** Улаанхуаран 1-р байр
- 2-р байр** Төв
- 3-р байр** Сансар
- 4-р байр** Шархад

#### **Ширээний теннис**

**Эрэгтэй**

**Эмэгтэй**



1-р байр Тамир  
2-р байр Уламбаяр  
3-р байр Түмэнжаргал  
4-р байр Мөнхдаваа

шалгарлаа.

1-р байр Сарантуяа  
2-р байр Гэрэлмаа  
3-р байр Шинэцэцэг  
4-р байр Энхцэцэг тус тус



➤ **Ажил танилцуулах, нээлттэй хаалганы өдөрлөг**

**Баянзүрх дүүргийн Биеийн тамир, спортын хорооны  
“НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ”**

Иргэдийн оролцоотой эрх зүйн шинэтгэлийн жилийн ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх Биеийн тамир спортын үйл ажиллагааг сурталчилах, тайлбарлах, санал хүсэлтийг сонсох иргэдийг өргөнөөр оролцуулах зорилготой нээлттэй хаалганы өдөрлөгт Баянзүрх дүүргийн Биеийн тамир спортын хорооны хамт олон амжилттай оролцлоо.



Нээлтэнд Баянзүрх дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн тамирчид нээлтийн арга хэмжээнд жагслаа.

Нийслэлийн удирдлагууд Биеийн тамир спортын хорооны үйл ажиллагаатай танилцан иргэдийн болон Биеийн тамир спортын хорооны дэргэдэх Дэвжих клубын ахмад тамирчидын саналыг сонсон ярилцав.



Өдөрлөгийн үеэр Баянзүрх дүүргийн Биеийн тамир спортын хороо, Усан бассейн, Жим арт фитнес клуб, Биеийн тамир спортын хорооны дэргэдэх Дэвжих клубын үйл ажиллагааг сурталчилан иргэдэд танилцуулж иргэдээс санал асуулга аван Улаанбаатар Марафоны бүртгэлийг анкетаар авлаа. Иргэдийн спортын наадмын төрөлд ордог Спорт Явган аялалын спортыг иргэд олон нийтэд сурталчилан, үзүүлэн танилцуулж иргэдэд зөвлөгөө мэдээллийг өгч аялал сонирхсон иргэд тус клубт орохоор бүртгүүлээ.



Мөн төв тайзан дээр Биеийн тамир спортын үйл ажиллагаа, Спорт явган аялалыг сурталчилсан танилцуулга мэдээллийг хүргэн, үзүүлэх тоглолтыг зохион байгууллаа. Өдөрлөгт оролцсон иргэдэд амьдралд хэрэгтэй 10 дасгал, компьютертэй ажилладаг хүмүүст зөвлөмж, биеийн тамир спортын тухай хуулиас, эмнэлгийн анхан шатны тусламж, дасгал хөдөлгөөний үе дэх хяналт, архи тамхинаас гарах арга, бие бялдарын сорил, стрессийн эсрэг зэрэг 20 төрлийн 500

гаруй гарын авлага боршурын иргэдэд тараалаа. Өдөрлөгийн үеэр Дарстын спортыг сурталчилан иргэдийн дунд чөлөөт тоглолт хийлээ.

### **Баянзүрх дүүргийн Биеийн тамир, спорт хорооны “АЖИЛ ТАНИЛЦУУЛАХ ӨДӨРЛӨГ”**

Дүүргийн засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээнд тусгагдсан Биеийн тамир спорт хорооны үйл ажиллагааны хөтөлбөрт орсон томоохон арга хэмжээний нэг болох Баянзүрх дүүргийн биеийн тамир, спорт хорооны “АЖИЛ ТАНИЛЦУУЛАХ ӨДӨРЛӨГ” 2017 оны 05 сарын 27-ны өдөр Жуковын талбай дээр амжилттай болж өндөрлөлөө. Өдөрлөгийн арга хэмжээний төлөвлөгөө болон хөтөлбөр гарган БТСХ-ны даргаар батлуулж бэлтгэл ажлаа хангалаа.

Тус өдөрлөгт Баянзүрх дүүргийн Эдийн засаг хөгжлийн асуудал хариуцсан төслийн удирдагч Засаг даргын орлогч Д. Уламбаяр, Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга С. Сувд-Эрдэнэ, Нийслэлийн нийтийн биеийн тамир спорт, хорооны мэргэжилтэн Г.Бямбасайхан, Б.Түвшинбаяр, Чингэлтэй дүүргийн биеийн тамир спорт хорооны дарга Р. Очирпүрэв болон бусад дүүргийн Биеийн тамир, спорт хорооны мэргэжилтэнгүүд хүрэлцэн ирсэн бөгөөд үйл ажиллагааг Баянзүрх дүүргийн Биеийн тамир, спорт хорооны дарга С. Эрдэнэбат нээж үг хэллээ.



Өдөрлөгийн нээлтэнд Баянзүрх дүүргийн ЭМТ-ийн Сансартуяа багштай хийн дасгалын ахмадын төлөөлөл Сансарын тунелээс –Жуковын талбай хүртэл өглөөний 10000 ахлалт хийж хүрэлцэн ирсэн зочид төлөөлөгч, иргэдэд хийн дасгал хийж сонирхууллаа.

Мөн нээлтийн үйл ажиллагаанд Баянзүрх дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн тамирчид, 21 дүгээр сургуулийн хүүхэд багачууд урлаг, спортын үзүүлэх тоглолт хийлээ. Баянзүрх дүүргийн Биеийн тамир спорт хороо нь



2017 оны хагас жилийн ажлын тайланг тавьхаас гадна 2016 оны шилдэг спортын хамтлаг, байгууллагуудын үйл ажиллагааг иргэдэд сурталчилах зорилгоор тэдний төлөөлөл болгож 97-р сургууль, Шавь цогцолбор сургууль, 48-р сургууль, 4-р хороодыг урьж оролцуулсан



Мөн тус өдөрлөгт Баянзүрх дүүргийн сурагчдын төлөөлөлд дүүрэг, хот, улсдаа спортоор өндөр амжилт гаргаж спортын 1 дүгээр зэргийн шалгуурыг хангасан 5 тамирчинд үнэмлэхийг гардуулж өглөө. Өдөрлөгт хүрэлцэн ирсэн иргэдээс санал асуулгын анкетийг бөглүүлж, 18 төрлийн 300 гаруй гарын авлагыг тарааж, зөвөлгөө, мэдээлэл өгч ажиллалаа.



Өдөрлөгийн үеэр Иргэдийн дунд Гир өргөлт, дээсэнд үсрэлт, дартс гэсэн 3 төрлийн тэмцээн явуулж дүнг гарган эхний 3 байр эзэлсэн тамирчдыг у  
р  
а



хамрагдлаа.



а  
г  
н  
а

- **Хүн амын бие бялдарын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорил**

Үйл ажиллагаанд нийт 6 байгууллагын 150 хүн оролцож 600 гаруй иргэд

**БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ХОРОО**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 053 дугаар зарлиг, дүүргийн Засаг даргын 2017 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн А/101 дүгээр захирамж гарган Засаг даргын Тамгын газар, харьяа хэлтэс, албад, хувийн хэвшлийн байгууллагуудын ажилтан албан хаагч иргэд, сургууль цэцэрлэгийн оюутан сурагч хүүхдүүдээс 2017 оны 4 дүгээр сарын 3-наас 5 дугаар сарын 31-ны хооронд дүүргийн хэмжээнд зохион байгуулж байна. Баянзүрх дүүргийн харьяа хэлтэсийн ажилтан, албан хаагчид, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш ажилтан, сурагч хүүхдүүд, хороодын иргэдээс “Хүн амын бие бялдарын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил”-ыг авсан.



Сорилын багийн бүрэлдэхүүн дараах нэр бүхий мэргэжилтэн, багш нараас бүрдсэн.

Дарга	Т.Баясах Засаг даргын Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч
Гишүүд:	С.Сувд Биеийн тамир спорт хорооны мэргэжилтэн М.Одонбаяр Амгалан цогцолбор сургуулийн Биеийн тамирын багш Э.Цогзолмаа Шавь цогцолбор сургуулийн Биеийн тамирын багш Мөнхчимэг 14 дүгээр сургуулийн Биеийн тамирын багш Г.Гангаамаа 53 дугаар сургуулийн Биеийн тамирын багш С.Алтанзул 79 дүгээр сургуулийн Биеийн тамирын багш Б.Батзаяа 84 дүгээр сургуулийн Биеийн тамирын багш М.Амаржаргал 102 дугаар сургуулийн Биеийн тамирын багш С.Эрдэнэбат
Нарийн бичгийн	

дарга Биений тамир, спортын хорооны дарга нар тус тус сорилын багийн бүрэлдэхүүнд орж амжилттай зохион байгуулж ажиллалаа



Засаг даргын Тамгын газар, харьяа хэлтэс албадын ажилтан албан хаагчдаас 4 дүгээр сарын 10-наас 22-ны өдрийг дуустал бие бялдарын сорилыг аван үнэлгээ өглөө. Төрийн болон төрийн бус хувийн хэвшлийн байгууллагуудын ажилтан албан хаагчдын сорилыг утсаар холбогдож биечлэн уулзаж хуваарь



гарган авлаа.

Одоогийн байдлаар дүүргийн хэмжээнд 3-5 насны 1238, 6-8 насны 818, 9-11 насны 1018, 12-17 насны 1811, 15-64 насны 10574 хүн нийтдээ 15459 хүний бие бялдарын сорилыг авч үнэлэн онлайн бүртгэлээр шивж оруулаад байна.

### **Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын БТТ-“СОРИЛ” тэмцээн**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 053 дугаар зарлиг, Биений тамир спортын тухай хууль, Засгийн газрын 2009 оны 05, 2014 оны 34 тоот тогтоолууд, Нийслэл, дүүргийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2017 оны зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Баянзүрх дүүргийн ЕБС-н сурагчдын дунд Дүүргийн аварга шалгаруулах бие бялдарын хөгжилт чийрэгжилтийн сорилыг 2017 оны 09 дүгээр сарын 16-17-нд

зохион байгууллаа. Дүүргийн аварга шалгаруулах Сорил тэмцээнийг 79-р сургуулийн ногоон талбай дээр 11 насны ангиллаар зохион байгуулсан ба Ерөнхий боловсролын 16 сургуулийн 800 сурагчид оролцон хурд хүч авхаалж самбаагаа сорин оролцлоо.



➤ **“Улаанбаатар марафон-2017” олон улсын гүйлт**

**Улаанбаатар “Марафон-2017” Засаг даргын нэрэмжит  
шилжин явах цом**

Нийслэлийн Засаг даргын 2017 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн А/147 дугаар захирамжийн дагуу дүүргийн Засаг даргын 2017 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/88 дугаар захирамж, удирдамж гаргуулан Улаанбаатар Марафон Нийслэлийн Засаг даргын нэрэмжит шилжин явах цомыг хуваарийн дагуу 2017 оны 3 дугаар сарын 29-ний өдөр Дүүргийн боловсролын хэлтэсээс эхэлж 5 дугаар сарын 15-ны өдрийг дуустал

1. Засаг даргын Тамгын газар, харьяа хэлтэс, албад
2. Хороод
3. Их дээд сургууль
4. Ерөнхий боловсролын сургууль



5. Цэцэрлэг гэсэн 5 чиглэлд тус бүрд цом, удирдамж, хуваарь гарган цом аялуулж байгууллага тус бүр хуваарь төлөвлөгөө гарган ажиллалаа.

**“Марафон-2017” Засаг даргын нэрэмжит шилжин явах цом Баянзүрх дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудаар аялав**

Ерөнхий боловсролын 20 сургуулаар цом аялж байгууллага тус бүр хуваарь төлөвлөгөө гарган байгууллагынхаа ажилтан албан хаагчдын дунд спортын тэмцээн уралдаан, арга хэмжээнүүдийг зохион байгуулсан тайлан мэдээгээ өгөөд байна. Ерөнхий боловсролын сургуулийн 15000 гаруй багш, ажилчин, сурагчид хамрагдаж Улаанбаатар Марафоны сайтанд 1700 гаруй сурагч, 700 гаруй багш ажилчдыг бүртгэж, баталгаажуулан энгэрийн номер олгоод байна.



**“Марафон-2017” Засаг даргын нэрэмжит шилжин явах цом Баянзүрх дүүргийн хороодоор аялав**

Баянзүрх дүүргийн 28 хороогоор цом аялж байгууллага тус бүр хуваарь төлөвлөгөө гарган байгууллагынхаа ажилтан албан хаагчдын дунд 30 гаруй спортын тэмцээн уралдаан, арга хэмжээнүүдийг зохион байгуулсан тайлан мэдээгээ өгөөд байна. Хороодын 2000 гаруй ажилтан, албан хаагч, иргэдийг Улаанбаатар Марафоны сайтанд бүртгэж, баталгаажуулан энгэрийн номер олгосон




### **“Марафон-2017” Засаг даргын нэрэмжит шилжин явах цом Баянзүрх дүүргийн ЗДТГ, хэлтэс албадаар аялав**

Засаг даргын Тамгын газрын харьяа хэлтэс албадын 30 байгууллагаар амжилттай аялууллаа.

Цом аялах аяны хүрээнд нийтдээ 25 байгууллагын 300 гаруй ажилтан албан хаагчдыг хамруулж Улаанбаатар Марафоны сайтанд шивж оруулан энгэрийн дугаар олгож баталгаажууллаа.

Цом аялах аяны хүрээнд нийт 2300 гаруй ажилтан албан хаагчдыг хамруулж спортын тэмцээн уралдаанаа зохион байгуулж удирдамж заагдсан чиглэлийн дагуу арга хэмжээг амжилттай зохион байгуулж, тайлан мэдээгээ бүртгэлийн хамт бүх байгууллагууд ирүүллээ.



### **“Марафон-2017” Засаг даргын нэрэмжит шилжин явах цом Баянзүрх дүүргийн Цэцэрлэгүүдээр аялав**

Баянзүрх дүүргийн цэцэрлэгүүдээр амжилттай аялууллаа.

Цом аялах аяны хүрээнд нийтдээ 300 гаруй ажилтан албан хаагчдыг хамруулж Улаанбаатар Марафоны сайтанд шивж оруулан энгэрийн дугаар олгож баталгаажууллаа.

Цом аялах аяны хүрээнд 15 нийт 800 гаруй ажилтан албан хаагчдыг хамруулж спортын тэмцээн уралдаанаа зохион байгуулж удирдамж заагдсан чиглэлийн дагуу арга хэмжээг амжилттай зохион байгуулж, тайлан мэдээгээ бүртгэлийн хамт бүх байгууллагууд ирүүллээ.

### **“Марафон-2017” Засаг даргын нэрэмжит шилжин явах цом Баянзүрх дүүргийн Их, дээд сургуулиар аялав**

Баянзүрх дүүрэгт үйл ажиллагаагаа явуулдаг улсын болон хувийн хэвшлийн томоохон их дээд сургуулиудаар 2017 оны 04 сарын 05-ны өдрөөс 05 сарын 15 – ны хооронд аяллаа.

Тус арга хэмжээг зохион байгуулахдаа цом аялах хуваарыг гарган БТСХ-ны даргаар батлуулж, арга хэмжээг зохион байгуулах Засаг даргын захирамж, удирдамжын дагуу ажлын чиглэлийг гарган тухайн сургууль дээр зохион байгуулах

үйл ажиллагаа болон Марафон гүйлтэнд оролцох тамирчидыг хэрхэн бүртгүүлэх талаар арга зүйн заавар зөвөлгөөг хүргэн ажиллаа.

“Улаанбаатар Марафон-2017” Олон улсын гүйлтийн цом нийт 8 их дээд сургуулиар аяласан бөгөөд сургууль бүр санаачлага, идэвхи, үр бүтээлтэй ажил зохион байгуулж бүртгэлд оюутан залуусыг олноор хамруулж 400 гаруй оюутаныг баталгаажууллаа. Мөн Санхүү Эдийн Засгын дээд сургууль, MIU зэрэг сургуулиуд “Улаанбаатар Марафон-2017” цомыг аялуулах боломжгүй гэдгээ албан ёсоор мэдэгдлээ. Цом аялах хүрээнд их дээд сургуулийн нийт 3775 оюутан, багш нар оролцсон бөгөөд Үүнээс :Спортын 13 төрлөөр тэмцээн уралдаа зохион байгуулж 1324 оюутан багш оролцсон, 4 удаагийн цэвэрлэгээнд 1131 оюутан оролцсон, мод тарих арга хэмжээнд 250 оюутан оролцсон, Уулзалт, эрдэм шинжилгээний хурал 2 удаа зохион байгуулж 1070 оюутан оролцсон байна.

Цом аялаж байгаа мэдээлэлийг [Ub-Marathon](#) болон [Спорт хороо Баянзүрх](#) гэсэн БТСХ-ны албан Фэйсбүүк хуудсаар тасралтгүй мэдэллэл харуулж байлаа.

#### **Үндэсний батлан хамгаалахын их сургууль:**

“Улаанбаатар Марафонд нэгдэцгээе” уриан дор “Улаанбаатар Марафон” цомыг 04 дүгээр сарын 10-13-ны өдрүүдэд хүлээн авч аялуулсан болно.

Цом хүлээн авах хүндэтгэлийн ажиллагаанд Баянзүрх дүүргийн Биеийн тамир, спортын хорооны дарга, Монгол Улсын гавьяат дасгалжуулагч С.Эрдэнэбат, Биеийн тамир, спортын хорооны ахлах мэргэжилтэн, Олон Улсын



шүүгч Ю.Батсайхан нар уригдан оролцсон бөгөөд ХСИС-ийн Цэргийн зохион байгуулалтын албаны дарга, Цагдаагийн дэд хурандаа Н.Цэдэвсүрэн, ҮБХИС-ийн Сургалт хариуцсан дэд захирал хурандаа П.Жаргаланд цомыг хүлээлгэн өгсөн байна.

Цом аялах хугацаанд тус сургууль “Улаанбаатар Марафон” Олон Улсын гүйлтийн заавар журмыг танилцуулан, “ҮБХИС-ИХ МАРАФОН” нэрэмжит цэргийн



албан хаагчдын дунд бүх нийтийн гүйлтийг Хужирбулангийн районд амжилттай зохион байгуулж явууллаа. Мөн тус арга хэмжээний хүрээнд буудлагын үндэсний шигшээ багийн ахлах дасгалжуулагч, Монгол Улсын гавьяат дасгалжуулагч дэд хурандаа Б.Ундралбат, Зэвсэгт хүчний “Алдар” спорт хорооны чөлөөт бөхийн дасгалжуулагч, Монгол Улсын гавьяат дасгалжуулагч Ц.Хосбаяр, “Самбо” бөхийн дэлхийн 3 удаагийн аварга, Монгол Улсын гавьяат тамирчин, ҮБХИС-ийн БТССТ-ийн ахлах багш, ахмад Б.Батдэмбэрэл нарыг урин оролцуулж сонсогчдын асуусан асуулт, спортын амьдралынхаа түүхээсээ ярьж, санал солилцсон арга хэмжээ боллоо. Энэ уулзалт арга хэмжээг Монголын үндэсний телевизийн “Эх орны төлөө” дуулга студын захиалгат нэвтрүүлэгтэй хамтран эх орон даяар сурталчлах ажлыг зохион байгуулсан байна.



Мөн оюутан, залуучуудад их спортыг сурталчлах, бие бялдрын бэлтгэлжилтийн өв тэгш хүмүүжил олгох зорилгоор хөнгөн атлетикийн олон төрөлт болон бусад төрлийн тэмцээнийг амжилттай зохион байгуулан явууллаа.

Тус тэмцээнд 480 гаруй тамирчид оролцсноор, спортын мастер 2, спортын зэрэг цолтой 50 гаруй тамирчид оролцсон нь тэмцээний ур чадвар, чанар чансааг харуулсан томоохон тэмцээн уралдаан болсон гэж дүгнэсэн болно.

**Отгон тэнгэр их сургууль** : “Улаабаатар Марафонд нэгдэцгээе” уриан дор “Улаанбаатар Марафон” цомыг 04 дүгээр сарын 25-05 сарын 04 -ны өдрүүдэд



хүлээн авч аялуулсан болно. Улаанбаатар марафон-2017 цом аялах хүрээнд ОТИС-ийн А байрны урдах талбайд шар хуайс, голт бор зэрэг модлог ургамалуудыг оюутнуудын хамтаар суулгасан.

Мөн сургуулийн ойр орчим хашаа ханан дээр наасан янз бүрийн зар сурталчилгааны цаас болон тамхины иш, хогыг цэвэрлэж ЭКО аянд нэгдсэн.



Улаанбаатар марафон-2017 шилжин явах цом Отгонтэнгэр их сургуулиас Газарчин дээд сургууль: дээр 5 сарын 4-нд хүрэлцэн ирлээ.



## ШУТИС-Мэдээлэл Холбооны Технологын Сургууль:

Баянзүрх дүүргийн 22-р хороонд орших ШУТИС-ийн Мэдээлэл Холбооны Технологийн Сургуулийн УЛААНБААТАР-2017 цомын аяны хүрээнд 2017-05-10наас 2017-05-12ны өдрүүдэд сургуулийнхаа нийт 94 багш ажилчидын дунд 4төрөл тэмцээнийг амжилттай зохион байгуулж дууслаа.

Тэмцээн нь сагсан бөмбөг, гар бөмбөг, ширээний теннис, шатар гэсэн 4-н төрлөөр зохион байгуулсан ба 5 салбарын 94 багш ажилчид хамрагдсаны 4 нь эрэгтэй, 45 эмэгтэй багш, ажилтан байсан болно.

“Улаанбаатар Марафон” цомыг ШУТИС –Бизнесийн сургуулиас **Улаанбаатарын Их сургууль:** хүлээн авч 04 дүгээр сарын 18-21-ний өдрүүдэд аялуулсан болно. Цомыг хүлээн авах ажиллагаанд Баянзүрх дүүргийн спорт хорооны ахлах мэргэжилтэн, Олон Улсын шүүгч Ю.Батсайхан, ШУТИС – Бизнесийн сургуулийн төлөөлөл Улаанбаатарын Их сургуулийн захирал С.Байгалсайханд (Sc.D, професор) хүлээлгэн өглөө.



Цом аялах аяны хүрээнд оюутан залуусыг спортод дур сонирхолтой болгох, нөхөрсөг багаар ажиллах чадварыг сайжруулах зорилготой 4 дүгээр сарын 15-ны өдөр тус сургуулийн нийт оюутнуудын дунд сургуулийн аварга шалгаруулах холимог волейболын тэмцээн зохион байгуулж эхний гурван байр эзэлсэн баг тамирчдыг медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж, нэг тамирчныг шилдэг

тоглогчоор шалгаруулж мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа. Улаанбаатарын Их сургуулиас 21 дэх жилдээ зохион байгуулж буй нэрт эрдэмтэн “Герасимовичийн семинар” олон их, дээд сургуулиудийн оюутнуудын дунд амжилттай явагдаж шилдэгүүдээ тодрууллаа. Хурлын ерөнхий шүүгчээр Ц.Эрдэнэбат Ph.D., профессор ажиллаж, нийт сургуулиудаас шалгарсан илтгэлийг хэлэлцүүллээ.

Хоггүй цэвэр орчинд сурч, ажиллаж амьдрах орчныг бүрдүүлж, оюутнууд, аж ахуйн ажилтнуудынхаа тус дэмээр сургуулийн болон хашааны гаднах ойр орчмыг цэвэрлэж хоггүй болголоо.



**Хууль сахиулах их сургууль:** Хууль Сахиулах Их Сургуульд гардууллаа. ХСИС-Соёмбо спорт хорооны хамт олон Марафоны цом аялуулах арга хэмжээнд өндөр ач холбогдол өгч хүндэтгэлтэйгээр хүлээн авлаа.Энэ үеээр сургуулийн



Марш тактикын аварга шалгаруулах тэмцээнийг амжилттай зохион байгууллаа.

**Их Засаг ОУИС:** нийт оюутнууд, удирдлагууд хүндэтгэлтэйгээр хүлээн авч УЛААНБААТАР МАРАФОН-2017 олон улсын гүйлтэнд нэгдэж буйгаа илэрхийллээ.



Энэ үеэр Дугуйн парад зохион байгуулж арга хэмжээнд 200 гаруй оюутан оролцлоо.

**Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль Бизнесийн Удирдлага Хүмүүнлэгийн Сургууль:** Нийслэлийн засаг даргын захирамжийн дагуу улаанбаатар марафон-2017 олон улсын гүйлтийн цом шилжүүлэх аяны хүрээнд зохион байгуулагдах хаврын тэргүүн шалгаруулах спортын 3 төрөлт тэмцээн, Гадана талбайн цэвэрлэгээ, дотно цэвэрлэгээг амжилттай зохион байгуулагдлаа.

### **БХИС – иас Цом хүлээн авах үйл ажиллагаа**





## “Улаанбаатар марафон-2017” олон улсын гүйлтийг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллаа

Нийслэлийн Засаг даргын 2017 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн А/147 дугаар захирамжийн дагуу дүүргийн Засаг даргын 2017 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/88 дугаар захирамж, удирдамжийн дагуу 2017 оны 05-р сарын 20-ны “Улаанбаатар марафон-2017” олон улсын гүйлтэнд Баянзүрх дүүргийн Биеийн тамир спорт, хорооны ажилтан албан хаагчид бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллалаа.

Нийслэлийн нийтийн биеийн тамир спортын хорооноос ирсэн хуваарийн дагуу Сансарын тунелын уулзвар дээр байрлах усны цэг дээр өглөө 06:00-17:00 цагийн хороонд Баянзүрх дүүргийн мэргэжилтэн Уянга ажиллаж бусад мэргэжилтэнгүүд хуваарийн дагуу бөхийн өргөө, талбайн гараа бариа, спортын нээлттэй хаалганы өдөрлөгт зориулан зассан асарт тус тус ажиллалаа.



Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газар хуваарийн дагуу тухайн бүс нутагт удирдамж, зааврын дагуу ажилласнаас гадна Бөхийн өргөөний урд талбайд тайз засаж дүүргийн Биеийн тамир спорт, хорооны өсвөрийн шигшээ багийн тамирчид 3 төрлийн үзүүлэх тоглолт мөн соёлын төв өргөөний дугуйлангийн хүүхэд багачууд урлагийн тоглолт хийж баянзүрх дүүргийн иргэдийн нэгдсэн арга хэмжээг зохион байгуулсан.

Мөн талбай дээр Биеийн тамир спортын газраас зохион байгуулсан Биеийн тамир, спортын нээлттэй хаалганы өдөрлөгт оролцож Баянзүрх дүүргийн биеийн тамир спортын хороо, дүүргийн нутаг дэвсгэр үйл ажиллагаа явуулж байгаа фитнесс клубын төлөөлөл, спорт аялалын холбооны баянзүрх дэхь салбар зөвлөл оролцож өөрсдийн үйл ажиллагааг иргэдэд сурталчилж, мэдээ мэдээлэл өгч, дүүргийн спорт хорооноос гаргадаг 10 гаруй төрлийн



1000 гаруй гарын авлага, зөвлөмж зэргийг иргэдэд тарааж, зөвөлгөө өгч ажилласан.



Улаанбаатар марафон-2017 олон улсын гүйлтэнд Баянзүрх дүүргийн сургууль, цэцэрлэг, хороодын иргэд, байгууллагуудын ажилтан албан хаагчид идэвхитэй оролцлоо.

Мөн Монголын мастеруудын Биеийн тамир спортын хороо Баянзүрх дүүргийн салбар зөвлөлийн гишүүд амжилттай оролцож 1 алт, 2 мөнгө, 5 хүрэл медалийн эзэд болсон



### “УЛААНБААТАР МАРАФОН-2017” ОЛОН УЛСЫН ГҮЙЛТИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААН

Нийслэлийн Засаг даргын 2017 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн А/147 дугаар захирамжийн дагуу дүүргийн Засаг даргын 2017 оны 03 дугаар сарын 28-ны



өдрийн А/88 дугаар захирамж, удирдамж гаргуулан Улаанбаатар Марафон Нийслэлийн Засаг даргын нэрэмжит шилжин явах цомыг хуваарийн дагуу 2017 оны 3 дугаар сарын 20-ноос 5 дугаар сарын 18-ны өдрийг дуустал 120 байгууллагаар аялуулж, Баянзүрх дүүрэгт 5 чиглэлд амжилттай зохион байгуулж аялууллаа.

Үүнд:

1. Засаг даргын Тамгын газар, харьяа хэлтэс, албадХороод
2. Их дээд сургууль
3. Ерөнхий боловсролын сургууль
4. Цэцэрлэг гэсэн 5 чиглэлд тус бүрд цом, удирдамж, хуваарь гарган цом аялуулж байгууллага тус бүр хуваарь төлөвлөгөө гарган ажиллалаа.

Байгууллагууд ажилтан албан хаагчдын дунд тэмцээн уралдаан, арга хэмжээнүүдийг зохион байгуулж нийтдээ 110900 гаруй ажилтан албан хаагч, оюутан сурагч иргэд хамрагдсан дүн мэдээтэй байна.

Цом аялах аяны хүрээнд бүх байгууллагуудын цом аялсан тайлан мэдээг хүлээн авсан бөгөөд байгууллага бүр идэвхи зүтгэлтэй, үр бүтээлтэй сайн оролцлоо.

Улаанбаатар Марафоны бүртгэлд Баянзүрх дүүрэг 5444 гаруй төрийн албан хаагч, хороодын иргэд, их, дээд сургуулийн оюутнууд, ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, цэцэрлэгийн багш ажилчидыг бүртгэлийг анкетаар авч, сайтанд 5444 гаруй хүнийг шивж оруулаа.

Мөн Улаанбаатар Марафоны 50 ширхэг плакат хэвлүүлэн томоохон хэлтэс, албад, аж ахуй нэгж байгууллагуудад тараан байршуулаад байна. Дүүргийн Хэвлэл мэдээллийн албатай хамтран Улаанбаатар Марафоны явцын талаархи мэдээллийг тогтмол сайтуудаар мэдээллэж, дүүргийн спорт хорооны албан ёсны фасебоок хаяг болох Спорт хороо Баянзүрх хуудсанд тогтмол мэдээллээ оруулж байлаа.

Нийслэлийн Засаг даргын захирамжийн дагуу дүүргийн Засаг даргын захирамж гаргуулан удирдамж, заавар, холбогдох бичиг баримтуудыг дүүргийн Засаг даргын Тамгын газар, харьяа хэлтэс албад, сургууль, цэцэрлэг, хороод, их дээд сургуулиудаар тараасан.

“Улаанбаатар марафонд нэгдэцгээе” Нийслэлийн Засаг даргын нэрэмжит цом аялуулах аяны удирдамжийн хүрээнд

1. Дүүрэг хороо хэсгийн иргэдийнхээ болон байгууллага, хамт олныхоо дунд “Улаанбаатар Марафон”-ыг дэмжих Нийслэлийн Засаг даргын нэрэмжит цомыг аялуулах хөтөлбөр, төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх

Улаанбаатар Марафоны захирамж гаргуулан байгууллагуудаар цом аялуулах хугацаандаа “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн талаар танилцуулж хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр олон нийтэд сурталчилсан. Мөн 5 дугаар сарын 13-14-ны өдрүүдэд Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд Марафонд оролцох хүмүүсийн бүртгэлийг хийж сурталчилгаа зохион байгуулж 120 гаруй хүнийг анкетаар авч энгэрийн дугаар олголоо.



2. Байгууллага дүүрэг, хороо хэсэгтээ байгаа “Биеийн тамир, спортын хамтлаг”-ийн үйл ажиллагааг дэмжих, эрчимжүүлэх, шинээр хамтлаг байгуулах ажлыг хийлээ.

Улаанбаатар Марафон-2017 цом аялах аяны хүрээнд бүх байгууллагууд спорт хамтлагаараа дамжуулан байгууллагынхаа ажилтан албан хаагчдын дунд тэмцээн уралдааныг амжилттай зохион байгуулсан.

Мөн дүүргийн өсвөрийн хөнгөн атлетикийн аварга шалгаруулах тэмцээнийг Улаанбаатар-Марафон аяны хүрээнд зохион байгуулж явуулсан.

Байгууллагуудаар цом аялуулах хугацаандаа мэдээллүүдийг Сүлд тв, Тв9 телевиз, дүүрэг болон спорт хорооны сайт, facebook UB-MARATON хуудсанд тогтмол мэдээлж байсан.

3. Байгууллага оршин суугаа орчиндоо хог хаягдалгүй цэвэр, эко орчинг бүрдүүлэх, амьдралын хүнд нөхцөлд байгаа өрх, иргэн, өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй, ахмад настай хүмүүст тусламж дэмжлэг үзүүлэх зэрэг сайн үйлсийг дэлгэрүүлэх, нийгэмд чиглэсэн хүмүүнлэгийн ажлуудыг зохион байгуулах, сурталчилах ажлын хүрээнд

2017 оны 04-р сард Биеийн тамир спорт хорооны ажилчид бүрэн бүрэлдэхүүнээрээ цэвэрлэгээнд гарлаа.

Цэвэрлэгээг 17 хорооны ажилтан албан хаагчидтай хамтран зохион байгуулж цэвэрлэгээг хуваарийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Замын хажуу талын хог болон хашлаганы хог, автобусны буудлын овоолсон хог, ахуйн гаралтай хог хаягдал, хуримтлагдсан цас мөс болон цэвэрлэж цуглуулж овоолсон хогоо нийтлэг үйлчилгээний хогны машин дуудаж хогоо ачиж явууллаа. Мөн шон болон автобусны буудал дээр, хашаанд наасан зарлал, плакатыг хуулж цэвэрлэлээ.

4. “Улаанбаатар Марафон” олон улсын гүйлтийн заавар журмыг танилцуулах, байгууллага, хамт олон, хороо хэсгээрээ марафонд нэгдэх, гүйх хөдөлгөөн өрнүүлэх, байгууллагаас марафонд оролцож гүйх хүмүүсийн нэрсийг гарган бүртгэлд хамруулах, байгууллага, хамт олныхоо дунд спортын төрөл бүрийн уралдаан тэмцээн зохион байгуулах, спортын алдар, цуутай тамирчидтай уулзалт ярилцлага хийх, мэргэжлийн багш дасгалжуулагчдыг урьж сургалт семинар зохион байгуулах, зөвлөгөө авах, хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр нэвтрүүлэг, ярилцлага, реклам сурталчилгаа хийлээ.

Улаанбаатар Марафоны 50 ширхэг плакат хэвлүүлэн томоохон хэлтэс, албад, аж ахуй нэгж байгууллагуудад тараан байршуулаад байна. Дүүргийн Хэвлэл мэдээллийн албатай хамтран Улаанбаатар Марафоны явцын талаархи мэдээллийг тогтмол сайтуудаар мэдээллэж, дүүргийн спорт хорооны албан ёсны фэйсбук хаяг болох Спорт хороо Баянзүрх хуудсанд тогтмол мэдээллээ оруулж байлаа. Байгууллага болгон өөрсдийнхөө ажилтан албан хаагч иргэдийн дунд тэмцээн уралдаан зохион байгуулж Улаанбаатар Марафоны бүртгэлд амжилттай бүртгүүлээ.

5. Нийслэлийн “Цэвэр агаар-нэг мод хөдөлгөөн”, Спорт төгөл байгуулах аянд байгууллага, хороо хэсгээрээ нэгдэн мод бут суулгах аянд оролцох, хандив дэмжлэг үзүүлээ.

Биеийн тамир спортын хорооны ажилтан албан хаагчид бүх нийтээр мод тарих аяны хүрээнд нэг хүний 5000 төгрөг нийтдээ 35000 төгрөгийг мод тарих үйлсэд дэмжлэг үзүүлэн хандивлалаа. Мөн байгууллагууд тус тусдаа өөрсдийн хуваарьлагдсан газар мод бут тарьсан.

### ➤ “UB.SPORT 2017”

Нийслэлийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний хүрээнд “UB.SPORT 2017” биеийн тамир, спортын өдөрлөгийг 2017 оны 10 сарын 7-ны өдөр Д.Сүхбаатарын талбайд Нийслэлийн нийтийн биеийн тамир, спорт хороо болон Баянзүрх дүүргийн биеийн тамир, спорт хороон дарга С.Эрдэнэбат-аар батлуулсан хөтөлбөрийн дагуу өдөрлөгийг амжилттай зохион байгууллаа.




Тус өдөрлөгт Баянзүрх дүүргийн 28 хороодын 200 гаруй иргэн, Хууль сахиулахын их сургуулийн 150 сонсогч, “Дэвжих” спорт явган аялалын клуб, Ахмад мастеруудын холбоо, Усан спорт сургалтын төв, Өсвөрийн шигшээ баг бүрэн бүрэлдэхүүнээрээ хамтран нээлтийн үйл ажиллагаа болон өдөрлөгийн нийтийг хамарсан уралдаан тэмцээнд оролцлоо. Мөн Оргилмаа дасгалжуулагчтай гимнастик болон Болд дасгалжуулагчтай Тэшүүрийн өсвөрийн шигшээ багийн тамирчид нээлтийн үйл ажиллагаанд үзүүлэх тоглолт хийлээ.

Баянзүрх дүүргийн биеийн тамир, спорт хороо, Ширээний теннисны холбоотой хамтрана ширээний теннисний тэмцээнийг зохион байгуулж тэмцээнд эрэгтэй, эмэгтэй нийт 68 тамирчин өрсөлдсөн.



Баянзүрх дүүргийн биеийн тамир, спорт хорооноос чөлөөт даамны тоглолтыг өдөрлөгийн туршид 100 гаруй иргэдийн дунд явууллаа. Мөн Гир өргөлт, Дээс тоглох Өдөн бөмбөг тоглох 3 төрөлт тэмцээн зохион байгууллаа. Өдөрлөгийн сонирхож ирсэн иргэдээс (Биеийн тамир, ёспортын үйлчилгээг иргэдэд хүргэх чиглэлээр ) санал асуулга авч, “Амьдарлын буруу хэвшлээс үйдэлтэй өвчнөөс сэргийлэх, хяна 1000 гаруй гарын авлага тарааж, сурталчилгаа явууллаа.





### 3. Иргэдийн спортын VI наадам

Монгол улсын Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийг үндэслэн нийслэлийн Засаг даргын 2013 оны 03 сарын 27-ний өдрийн А/333 захирамж Дүүргийн Засаг даргын 2017 оны 07 сарын 20-ний А/222 захирамж, Биеийн тамир, спортыг хөгжүүлэх, дүүргийн иргэдэд биеийн тамир, спортын үйлчилгээг чанартай хүртээмжтэй хүргэх, “Биеийн тамир спортыг айл өрх, иргэн бүрт” уриатайгаар зохион байгуулагдаж байгаа Иргэдийн спортын VI наадам 2017 оны 06 дугаар сараас 11 сарын хугацаанд

- 1, 2 шат - хороодын хэсгийн тэмцээн -2017.06-01 - 09.20 хооронд
- 3 шат - дүүргийн бүс аварга - 2017.09.23 - 10.01 хооронд
- 4-р шат - дүүргийн аварга -2017.10.02 10-15 хооронд
- 5 шат – нийслэлийн аварга - 2017.10.16-2017.11.06 гэсэн 5 үе шаттайгаар Сагсан бөмбөг, **Волейбол**, **Софт волейбол**, **Олс таталт**, **Ширээн шагайн наадгай**, **Хийн дасгал**, **Аэробик**, **Спорт явган аялал** гэсэн 7 спортын төрлөөр дүүргийн иргэдийн дунд амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө.. Дүүргийн 28 хороог газар нутаг, хүн амын тоо зэргээс нь хамааруулж 4 бүсэд хуваасан болно. Улмаар бүсийн тэмцээнийг зохион байгуулж шалгарсан багуудыг Дүүргийн аварга шалгаруулах тэмцээнд оролцуулж спортын төрөл тус бүрт 1- р байр эзэлсэн багуудыг Нийслэлийн иргэдийн V наадмын шигшээ тэмцээнд оролцууллаа. Тэмцээнд **23** хорооны **766** багын **10653** иргэд давхардсан тоогоор хамрагдаад байна.

2017 оны 11 сарын 05-06-д зохион байгуулагдсан Нийслэлийн шигшээ тэмцээнд:

- 18, 8- р хорооны Волейболын эмэгтэй баг
- 18-р хороо Софт волейбол
- 9, 6-р хорооны Сагсан бөмбөгийн эмэгтэй баг
- 12, 9-р хорооны Олс таталтын багууд
- 27, 9 -р хорооны шагайн наадгайн багууд
- 4-р хорооны Хийн дасгалын багууд оролцлоо.

Иргэдийн наадмын хорооны сонгон шалгаруулах тэмцээнд **8375** хүн, **бүсийн аварга** шалгаруулах тэмцээнд **22** хорооны **1364** хүн хамрагдлаа. **Дүүргийн аварга** шалгаруулах тэмцээнд **22** хорооны **782** хүн, Нийслэлийн

шигшээ тэмцээнд 131 тамирчин оролцож Иргэдийн VI наадамд нийт 10653 хүн хамрагдсан байна.







## БАЯНЗҮРХ ДҮҮРИЙН ИРГЭДИЙН СПОРТЫН VI НААДМЫН НЭГДСЭН ДҮН

№	хороо	волейбол			Сагсан бөмбөг			Олс таталт			Шагайн наадгай			Хийн дасгал			Софт волейбол		Спорт аялал		Оноо		Байр	
		эр	эм	тоо	эр	эм	тоо	эр	эм	тоо	эр	эм	тоо	х/д	аэр	тоо	оно	тоо	оно	тоо	оноо	Х-тоо		
1	1-р	28	28	0	28	28	0	28	28	0	28	28	0	28	28	0	28	0	28	0	336	0	23-28	
2	2-р	6	6	16	8	12	12	8	6	18	8	8	14	28	28	0	28	0	28	0	174	60	11	
3	3-р	28	28	0	28	9	8	28	9	9	28	9	7	28	28	0	28	0	28	0	279	24	21	
4	4-р	3	3	16	6	10	12	8	10	18	6	11	14	1	1	36	3	6	2	13	64	115	2	
5	5-р	9	6	16	10	10	12	4	5	18	3	5	14	28	28	0	28	0	1	13	136	73	7	
6	6-р	28	28	0	28	3	7	28	28	0	28	28	0	28	28	0	28	0	28	0	311	7	22	
7	7-р	28	28	0	2	6	12	28	28	0	28	9	7	28	28	0	28	0	28	0	269	19	20	
8	8-р	1	10	16	6	10	12	3	8	18	9	7	14	5	5	36	28	0	28	0	120	96	5	
9	9-р	10	4	16	1	9	12	1	10	18	2	1	14	28	28	0	28	0	8	13	130	73	6	
10	10-р	8	11	16	10	8	12	10	9	18	9	10	14	28	28	0	28	0	28	0	187	60	14-15	
11	11-р	28	28	0	28	28	0	28	28	0	28	28	0	28	28	0	28	0	28	0	336	0	23-28	
12	12-р	28	28	0	28	28	0	28	1	9	28	3	7	28	28	0	5	6	9	13	242	35	18	
13	13-р	28	28	0	28	28	0	28	28	0	28	28	0	28	28	0	28	0	28	0	336	0	23-28	
14	14-р	10	10	16	9	6	12	28	4	8	28	2	7	28	28	0	28	0	28	0	209	43	17	
15	15-р	28	28	0	28	28	0	28	28	0	28	28	0	5	5	36	2	6	28	0	264	42	19	
16	16-р	9	8	16	4	1	12	8	7	18	11	11	14	3	3	36	28	0	6	13	99	109	4	
17	17-р	10	10	16	10	11	12	11	11	18	11	10	14	28	28	0	28	0	3	13	171	73	9	
18	18-р	2	1	16	28	28	0	28	28	0	5	4	14	28	28	0	1	6	10	13	191	49	16	
19	19-р	10	10	16	10	9	12	10	9	18	8	9	14	28	28	0	28	0	28	0	187	60	14-15	
20	20-р	28	10	8	9	10	12	11	11	18	11	11	14	2	2	0	28	0	7	13	140	65	8	
21	21-р	28	28	0	28	28	0	28	28	0	28	28	0	28	28	0	28	0	28	0	336	0	23-28	
22	22-р	28	28	0	28	28	0	28	28	0	28	28	0	28	28	0	28	0	28	0	336	0	23-28	
23	23-р	9	9	16	3	11	12	10	9	18	4	11	14	28	28	0	28	0	28	0	178	60	10	
24	24-р	10	9	16	9	4	12	9	10	18	10	10	14	28	28	0	28	0	28	0	183	60	12	
25	25-р	28	28	0	28	28	0	28	28	0	28	28	0	28	28	0	28	0	28	0	336	0	23-28	
26	26-р	4	9	16	9	9	12	9	9	18	9	10	14	4	4	18	4	6	5	13	85	97	3	
27	27-р	6	2	16	8	2	12	2	2	18	1	6	14	5	5	36	5	6	4	13	48	115	1	
28	28-р	8	8	16	11	8	12	9	8	18	10	10	14	28	28	0	28	0	28	0	184	60	13	
29	бүгд			264			231			296			196			180		36		130			1333	
БАЯНЗҮРХ ДҮҮРИЙН ИРГЭДИЙН СПОРТЫН VI НААДМЫН БҮСИЙН ТЭМЦЭЭНД ОРОЛЦСОН ТАМИРЧДЫН ТОО																					1120			
БАЯНЗҮРХ ДҮҮРИЙН ИРГЭДИЙН СПОРТЫН VI НААДМЫН ХОРОО ХЭСГИЙН ТЭМЦЭЭНД ОРОЛЦСОН ТАМИРЧДЫН ТОО																					8553			
НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН СПОРТЫН VI НААДАМД ОРОЛЦСОН ТАМИРЧДЫН ТОО																								
		9	9	18	13	13	26	9	9	18	7	7	14	18	18	36		6		13			131	
БАЯНЗҮРХ ДҮҮРИЙН ИРГЭДИЙН СПОРТЫН VI НААДМЫН 7 ТӨРЛИЙН ТЭМЦЭЭН УРАЛДААНД ДАВХАЦСАН ТООГООР ОРОЛЦСОН ТАМИРЧДЫН ТОО																					10653			

### Баянзүрх дүүргийн Иргэдийн спортын VI наадмын хаалтын шагнал гардуулах ёслолын Галла тоглолт

2017 оны 11 сарын 03-ны өдөр Жанжин соёлын төвд дүүргийн Иргэдийн спортын VI наадмын хаалтын ёслолын шагнал гардуулах арга хэмжээ болж өндөрлөлөө.

Хаалтын ёслолын хүндэт зочноор:

- Баянзүрх дүүргийн Засаг даргын Т. Баясах
- Баянзүрх дүүргийн Засаг даргын орлогч Д. Уламбаяр
- Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга С. Сувд-Эрдэнэ болон мэргэжилтэнгүүд
- Биеийн тамир, спортын хорооны дарга С. Эрдэнэбат нар оролцов.

Ёслолын үеэр Засаг даргын дэрэгдэх өсвөрийн шигшээ багийн тамирчид үзүүлэх тоглолт хийж Соёлын төвийн уран сайханчид урлагын тоглолт үзүүлсэн. Мөн тус арга хэмжээг МҮОНТ, TV9 телевизээс сурвалжлагын



баг ирж Иргэдийн наадмын талаар болон шагнал авсан иргэдээс ярилцлага авлаа.

Дүүргийн шигшээ тэмцээн 7 төрлөөр хорооны 1333 иргэн хамрагдсан бөгөөд дүүргийн иргэдийн спортын VI наадамд нийт 22 хорооны 10653 иргэн хамрагджээ.

### **Волейбол**

#### Эрэгтэй

1. А.Бямбадолгор Засаг даргатай 8-р хороо
2. Б.Туяасайхан Засаг даргатай 18-р хороо
3. Ц.Мандахбаяр Засаг даргатай 4-р хороо

#### Эмэгтэй

1. Б.Туяасайхан Засаг даргатай 18-р хороо
2. Л.Батдэлгэр Засаг даргатай 27-р хороо
3. Ц.Мандахбаяр Засаг даргатай 4-р хороо

### **Сагсан бөмбөг**

#### Эрэгтэй

1. Д.Ганхуяг Засаг даргатай 9-р хороо
2. С.Аварга Засаг даргатай 7-р хороо
3. Д.Энхтүвшин Засаг даргатай 23-р хороо

#### Эмэгтэй

1. С.Ганчимэг Засаг даргатай 16-р хороо
2. Л.Батдэлгэр Засаг даргатай 27-р хороо
3. Б.Одончимэг Засаг даргатай 6-р хороо

### **Олс таталт**

#### Эрэгтэй

1. Д.Ганхуяг Засаг даргатай 9-р хороо
2. Л.Батдэлгэр Засаг даргатай 27-р хороо
3. А.Бямбадолгор Засаг даргатай 8-р хороо

#### Эмэгтэй

1. Н.Мөнхтуяа Засаг даргатай 12-р хороо
2. Л.Батдэлгэр Засаг даргатай 27-р хороо
3. А.Бямбадолгор Засаг даргатай 8-р хороо

### **Ширээний шагайн наадгай**

#### Эрэгтэй

1. Л.Батдэлгэр Засаг даргатай 27-р хороо
2. Д.Ганхуяг Засаг даргатай 9-р хороо
3. М.Ширэндэв Засаг даргатай 5-р хороо

#### Эмэгтэй

1. Д.Ганхуяг Засаг даргатай 9-р хороо
2. Э.Батсайхан Засаг даргатай 14-р хороо
3. Н.Мөнхтуяа Засаг даргатай 12-р хороо

### **Спорт явган аялал**

1. М.Ширэндэв Засаг даргатай 5-р хороо
2. Ц.Мандахбаяр Засаг даргатай 4-р хороо
3. Л.Эрдэнэцэцэг Засаг даргатай 17-р хороо

### Софт волейбол

1. Б.Туяасайхан Засаг даргатай 18-р хороо
2. З.Ариунзаяа Засаг даргатай 15-р хороо
3. Ц.Мандахбаяр Засаг даргатай 4-р хороо

### Хийн дасгал, аеробик

1. Ц.Мандахбаяр Засаг даргатай 4-р хороо
2. Д.Отгонбат Засаг даргатай 20-р хороо
3. С.Ганчимэг Засаг даргатай 16-р хороотус тус шалгарж өргөмжлөл, медаль, мөнгө шагналаар шагнаж урамшуулав.

### БАГИЙН ДҮНГЭЭР

I Байр Л.Батдэлгэр Засаг даргатай-27р хороо

II Байр П.Мандахбаяр Засаг даргата -4-р хороо

III Б.Болормаа Засаг даргатай -26-р хороо





### Нийслэлийн иргэдийн спортын VI наадам


Нийслэлийн иргэдийн спортын VI наадмын шигшээ тэмцээн 2017 оны 11 сарын 05-06-ны өдрүүдэд Буянт-Ухаа спортын ордонд Сагсан бөмбөг, Волейбол, Софт волейбол, Олс таталт, Ширээн шагайн наадгай, Хийн дасгал, Аэробик, Спорт явган аялал гэсэн 7 спортын төрлөөр амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. Шигшээ тэмцээнд: Шилдэг хороогоор 26-р хороо, 18-р хорооны Волейболын эмэгтэй баг алтан медаль, 6-р хорооны Сагсан бөмбөгийн эмэгтэй баг хүрэл медаль, 27-р хорооны Ширээн шагайн наадгай эрэгтэй хүрэл медаль хүртэж нийлбэр оноогоор 5-р байрт шалгарлаа.





Нийслэлийн иргэдийн Vнаадмыг Баянзүрх дүүрэгт зохион байгуулсан, Нийслэлийн шигшээ тэмцээнд оролцсон тайлангаас болон дээрх харьцуулсан графикаас харахад бүс, дүүрэг, нийслэлийн шатанд оролцогчын тоо урьд жилийнхээс бага зэрэг цөөрсөн боловч хамрагдсан хороодын тоо өссөн үзүүлэлт гарчээ.

## Иргэдийн спортын VI наадмын хэсэг бүс, дүүрэг, нийслэлийн тэмцээнд оролцсон тамирчдын 2015, 2016, 2017 оны харцуулсан хүснэгт



### 4. Сургалт, семинар

#### Цэцэрлэгийн багш, арга зүйчдийн сургалт

Нийслэлийн биеийн тамир спортын газраас жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг нийслэлийн 9 дүүргийн цэцэрлэгийн багш, арга зүйч сургалт 2017 оны 01 дүгээр сарын 16-19-ний өдрүүдэд МУБИС-ийн харьяа Сургуулийн өмнөх боловсролын сургууль дээр амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө.



Сургалтанд Баянзүрх дүүргийн 30 цэцэрлэгийн 56-н багш сургалтанд хамрагдлаа. Сургалтаар цэцэрлэгийн багш нарын мэдлэг боловсролыг дээшлүүлсэн олон сургалт, семинаруудыг зохион байгуулсан. Мөн цэцэрлэгийн хүүхдүүдийн уран хөдөлгөөнт гимнастикийн заавал хийх дасгал хөдөлгөөнийг шинэчлэн заалаа



Сургалтанд оролцсон цэцэрлэгийн арга зүйч, багш нарт сертификат заавлын хөдөлгөөний ном, CD гардуулан өглөө.

### **Ерөнхий боловсролын сургуулиудын багш нарын сургалт**

Нийслэлийн биеийн тамир спортын газраас жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг нийслэлийн 9 дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудын багш нарын сургалт 2017 оны 02 дугаар сарын 23-27-ний өдрүүдэд Үндэсний Биеийн тамирын дээд сургуульд дээр амжилттай зохион байгуулагдлаа





Сургалтанд Баянзүрх дүүргийн ерөнхий боловсролын 17 сургуулийн 39-н багш сургалтанд хамрагдлаа. Сургалтаар биеийн тамирын багш нарын мэдлэг боловсролыг дээшлүүлсэн олон сургалт, семинаруудыг зохион байгуулсан.

Мөн жил бүр болдог Уран хөдөлгөөнт гимнастикийн бага ангийн заавал хийх шинэчилсэн дасгалыг заасан.



Нийслэлийн биеийн тамир спортын газрын мэргэжилтэн Мөнх-Эрдэнэ сургалтанд суусан багш, арга зүйчдэд сертификат, ном, CD гардууллаа.

### **Олон улсын “SPORT FOR CHILDREN” эрдэм шинжилгээний хурал**

Олон улсын хүүхдийн спортын VII наадамд оролцогч орны эрдэмтэн, судлаачдын дунд "SPORT FOR CHILDREN" Эрдэм шинжилгээний хурал 2017 оны 08 сарын 14 өдөр Пума ИмпериаЛ зочид буудлын Conference hall хурлын танхимд болсон.

"ХҮҮХДИЙН СПОРТ" сэдэвт Олон улсын эрдэм шинжилгээний хуралд БНХАУ-ын ӨМӨЗО, ОХУ-ын Буриад, Якут, Монголын эрдэмтэн судлаач нар оролцлоо. ОХУ-ын Буриад болон ӨМӨЗО-ны төлөөлөгчид тухайн орны өсвөрийн тамирчин хэрхэн бэлтгэж байгаа талаар сайхан илтгэл тавив. ОХУ-ын Якутын төлөөлөгч Азийн хүүхдийн наадмыг зохион байгуулах хорооны ерөнхийлөгч Евгениевич ГЛУШКОВ "АЗИЙН ХҮҮХДИЙН НААДАМ-2020" илтгэл уншсан ба энд уншигдсан бүх илтгэлүүд хүүхдийн хөгжил, төлөвшил, хүүхдийн





спортоор хичээллэх орчны асуудал байсан нь маш сонирхолтой байлаа. Эрдэм шинжилгээний хуралд 50 орчим судлаач ирсэн ба үүнд Нийслэл, дүүрэг, аймгуудын БТСГ-ын мэргэжилтэн, Жүдо, Чөлөөт бөх, Хүндийн өргөлт, Сагсан бөмбөг, Волейбол, Хөл бөмбөг, Гимнастик, Хөнгөн атлетикийн Спорт холбоодын төлөөлөгчид, сонирхогчид, Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан докторууд, Нийгмийн эрүүл мэндийн Үндэсний төвийн эрдэм шинжилгээний ажилтан, ҮБТДС-ийн доктор, профессор, докторантууд, МУБИС-ын докторууд, оролцсон бөгөөд МҮОХ-ны гишүүн, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн алба, хэлтсийн дарга, мэргэжилтнүүд, ЕБС-ийн багш гэх мэт олон олон төлөөллөөс бүрдсэн сайхан үйл ажиллагаа болж өндөрлөлөө.

### Baseball & Softball сургагч багш бэлтгэх сургалт

BASEBALL& SOFTBALL сургагч багш бэлтгэх сургалт 2017.09.25-26нд Монголын олимпын хорооны байранд амжилттай зохиогдож дууслаа. Сургалтанд USA, ITALI багш дасгалжуулагч болон дэлхийн BASEBALL&SOFTBALL холбооны мэргэжилтэн ирж сургалт хийлээ. Сургалтанд дүүргүүдийн биеийн тамир спорт хороодын мэргэжилтэн, ЕБС-ын багш нар болон “Аварга” биеийн тамирын их сургуулийн оюутнууд хамрагдлаа.



### Эрүүл ажлын байр -таниас эхэлнэ сургалт

Нийслэлийн биеийн тамир спорт хорооноос зохион байгуулсан Эрүүл ажлын байр таниас эхэлнэ сургалт 2017 оны 10 сарын 02 өдөр GB plaza 404 тоотод амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. Сургалтанд Баянзүрх дүүргийн БТСХороон 1 мэргэжилтэн биеийн тамир, спортын хамтлагын шилдэг 5 арга зүйч хамрагдлаа.




### **Чөлөөт бөхийн “Шүүгч бэлтгэх” хамтарсан сургалт семинар**

Монголын чөлөөт бөхийн холбоо, Үндэсний Биеийн тамирын дээд сургууль, Баянзүрх дүүргийн Биеийн тамир спортын хорооноос хамтран зохион байгуулсан Чөлөөт бөхийн шүүгч бэлтгэх онол, практикын сургалт семинар 2017 оны 11 сарын 10-11-ний өдрүүдэд амжилттай зохион байгуулагдлаа. Тус сургалтын онолын хичээл сургалт 11 сарын 10-ны өдөр ҮБТДС дээр болсон ба энэ арга хэмжээг нээж ҮБТДС-н дэд захирал Л.Гүндэгмаа, МЧБХ-ны шүүгчийн зөвлөлийн дарга Ц.Цэрэнхүү нар оролцогчдод амжилт хүсэж сургалтын ач холбогдлын талаар зөвлөгөө өглөө.

Сургалт семинарт нийт 63 хүн оролцсон бөгөөд зэрэг ахиулах болон шинээр зэрэг авах шалгалтанд хамрагдлаа. Шалгалтыг олон улсын сургалт семинарын жишигийн дагуу онол, видео, дадлагыг онооны нийлбэрээр тооцлоо. Сургалт батлагдсан хуваарь, хөтөлбөрийн дагуу сургагч багш нар онолын хичээл заасан бөгөөд багш нарын бүрэлдэхүүнд UWW-н олон улсын шүүгч Ц.Сэрээтэр, Ю.Батсайхан, А.Алтангадас, МЧБХ-ны гадаад харилцаа хариуцсан захирал П.Буяндэлгэр, ҮБТДС-н багш Чөлөөт бөхийн олон улсын дасгалжуулагч Ц.Баярсайхан нар байлаа.

2017 оны 11 дүгээр сар 11-ний өдрийн сургалт БЗД-н БТСХ, Амгалан цогцолбор сургуулийн спорт зааланд дадлагын хичээлээр үргэлжилсэн ба сургалтанд оролцогсод Нийслэлийн дүүргүүдийн өсвөрийн шигшээ эмэгтэй багийн аварга шалгаруулах тэмцээнийг шүүж дадлагын шалгалтаа өглөө. Дадлагын хичээлийн UWW-н олон улсын шүүгч Б.Эрдэнэболд, Л.Ганзориг нар удирдан явууллаа.

Энэхүү сургалтын үеэр МЧБХ-ны ерөнхий нарийн бичгийн дарга Б.Батбаяр, Үндэсний шигшээ багийн ахлах дасгалжуулагч Б.Баттулга нар хүрэлцэн ирж сургалт семинар болон өсвөрийн шигшээ эмэгтэй багуудын тэмцээнд амжилт хүсэж баяр хүргэсэн ба Чөлөөт бөхийн холбооноос, ач холбогдол өгч хамтран ажилласан ҮБТДС болон БЗД-н БТСХ-д талархал илэрхийллээ.



## ХИЙН ДАСГАЛ, АЭРОБЕКИЙН СУРГАЛТ

Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/333 захирамж, Дүүргийн Засаг даргын 2017 оны А/222 захирамжийн дагуу зохион байгуулагдаж байгаа Иргэдийн спортын VI наадмын Хийн дасгал, Аэробекийн спортын төрөлд Баянзүрх дүүргийн Биеийн тамир спортын хороо, Баянзүрх дүүргийн эрүүл мэндийн төвтэй хамтарж сургалт явууллаа. Сургалтыг БЗЭМТ-ийн Биеийн тамирын арга зүйч Б.Сансартуяа иргэдийн дунд хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх, дасгал хөдөлгөөний ач тус, идэвхитэй хөдөлгөөнийг сурталчилан сургалт зохион байгуулж Биеийн хэлбэрийн шүлэглэл, Мэдрэл сэргээж шөрмөс зөөллөх хийн дасгал, Жавхаат хэмнэл, золбоот хэмнэл дасгалуудыг насны ангиллаар нь зааж дүүргийн арга хэмжээнд нийт 28 хорооноос 12 хороодын 120 гаруй иргэдыг сургалтанд хамруулан оролцууллаа. Үйл ажиллагаанд оролцсон тамирчдаас хамгийн өндөр настай нь 75 настай иргэн байлаа. Дүүргийн хийн дасаглын тэмцээнд 4-р хорооны иргэд тэргүүн байр эзэлж нийслэлийн иргэдийн спорт наадамд амжилттай




оролцож тусгай байрт шалгарлаа.



## “Софт волейбол”-ын сургалт

Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/333 захирамж дүүргийн Засаг даргын 2017 оны А/222 захирамжийн дагуу зохион байгуулагдаж байгаа Иргэдийн спортын VI наадмын төрөлд шинээр нэмэгдэн орсон “Софт волейбол”-ын спортын сургалтыг 2017 оны 10 сарын 21нд ерөнхий боловсролын 21-р сургуулийн спорт заалнд, Монголын ахмад мастеруудын холбооны “Софт волейбол”-ын шүүгч Дэлгэр БЗД-ийн биеийн тамир спорт хороо хамтран зохион байгууллаа. Сургалтанд 15 хорооны 70 гаруй иргэд хамрагдлаа.



## “Нийтийн биеийн тамир, спортын хөгжил, цаашдын чиг хандлага” эрдэм шинжилгээний хурал

Нийслэлийн нийтийн биеийн тамир спортын хорооноос жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг Нийслэл дэхь "Нийтийн биеийн тамир, спортын хөгжил, цаашдын чиг хандлага" сэдэвт эрдэм шинжилгээ судалгааны шилдэг бүтээл шалгаруулах илтгэлийн уралдаан 2017 оны 12 дугаар сарын 08 нд Засгийн газрын XI байрны хурлын заалнд боллоо. Уралдаанд Нийслэлийн 9 дүүргийн биеийн тамир спортын хорооны мэргэжилтэнгүүд, ЕБС-ийн багш, Их дээд сургуулийн оюутанууд илтгэл тавилаа.

Эрдэм шинжилгээ судалгааны шилдэг бүтээл шалгаруулах илтгэлийн уралдаанд Баянзүрх дүүргээс 7 судлаач илтгэл тавьж хэлэлцүүлээ.

- Баянзүрх дүүргийн биеийн тамир спорт хорооны ахлах мэргэжилтэн Ю.Батсайхан “Өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагаа”.

- 87-р сургуулийн биеийн тамирын багш С.Гэрэлмаа “Нийтийн биеийн тамираар эцэг эхийн хандлага өөрчилөх нь”

- 85-р сургуулийн биеийн тамирын багш С.Чулуунсүх “Нийтийн биеийн тамирын чиглэлээр хийгдэж байгаа үйл ажиллагаа”

- 136-р бага сургуулийн Н. Идэрбат “Биеийн тамир спортын барилга байгууламж ба биеийн тамирын хичээлийн асуудал” сэдвээр тус тус илтэл тавилаа.

87-р сургуулийн багш С.Гэрэлмаа Тэргүүн байр, 85-р сургуулийн багш С.Чулуунсүх Дэд байрт шалгарч багийн дүнгээр тэргүүн байр эзэлж цом, өргөмжлөлийн эзэн боллоо.



### свөрийн шигшээ багийн үйл ажиллагаа

Өсвөрийн шигшээ багийг анх 2010 оны 05 сарын 13-ны 177 дугаар захирамжийн дагуу 9 төрлөөр байгуулагдсан бөгөөд үйл ажиллагаагаа хэвийн явуулж ирсэн. Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчын 2015.02.09 өдрийн №А/118 тоот захирамж, Дүүргийн засаг даргын 2015 оны 06 сарын 22-ний өдрийн А/285 тоот захирамжын дагуу Өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулсан.

2017 онд Шигшээ багийн бүрэлдэхүүнд байгаа 9-10 төрлийн спортоор секц дугуйланд 1130 хүүхэд хамрагдагдаж байгаагаас албан ёсны 65 тамирчинг шигшээ багийн гишүүнээр сонгон шалгаруулж уралдаан тэмцээнд оруулж байна. Шигшээ багийн үйл ажиллагаанд 2017 оны жилийн эцсийн байдлаар нийт: **27877,9** төгрөг буюу Төсвөөс **5737,9** төгрөг, Орон нутгийн төсвөөс **22140,0** төгрөг зарцуулаад байна.

Шигшээ багт багтсан спортын төрлүүдээр Дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг байнга зохион байгуулдаг бөгөөд хот, улс, олон улс, тив, дэлхийн тэмцээнүүдэд оролцуулж байна.



**Өсвөрийн шигшээ багийн тамирчид хот, улсын аварга шалгаруулах тэмцээнд Баянзүрх дүүргийг төлөөлөн, олон улс тивийн тэмцээнүүдэд Монгол улсыг төлөөлөн оролцдог. 2017 онд авсан медалийн тоо**

№	Дүүргийн өсвөрийн шигшээ багийн төрөл	Тамирчдын тоо	Дасгалжуулагчийн тоо	Үзүүлсэн амжилт											
				Тив дэлхийн тэмцээн			Олон улсын тэмцээн			УАШТ			Улаанбаатар хотын аварга ШТ		
				Алт	Мөнгө	Хүрэл	Алт	Мөнгө	Хүрэл	Алт	Мөнгө	Хүрэл	Алт	Мөнгө	Хүрэл
1	Жү-до бөх	6	1	2	1	1			2	6	5	6	4	4	2
2	Чөлөөт бөх	6	1				3					2			
3	Самбо бөх	6	1							4	3	7			
4	Бокс	6	1				1		3	2		5			
5	Ширээний теннис	6	1						2			2			
6	Волейбол	12	1							1				2	
7	Гимнастик	6	1					1	1	3	7	4	3	2	
8	Даам	6	1	7	4	2				15	9	11			
9	Тэшүүр	6	1							3	7	4			
10	Хөл бөмбөг	11	1												
Дүн		71	10	9	5	3	4	1	8	34	31	41	7	8	2
Нийт		153													

2017 оны 7-8-р саруудад Өсвөрийн шигшээ багийн Тэшүүр, Чөлөөт бөх, Гимнастикийн төрлүүдийн тамирчдыг зуны сэргэлтийн бэлтгэлд төсөв гарган 7 хоногийн хугацаатай хамрууллаа.

**-Чөлөөт бөхийн** өсвөрийн шигшээ багийн зуны сэргэлтийн бэлтгэл 2017 оны 08 сарын 20-26-ны өдрүүдэд батлагдсан хуваарийн дагуу явагдлаа. Тус бэлтгэлд 10 өсвөрийн тамирчид болон 2 багш дасгалжуулагчид оролцлоо. Сэргэлтийн бэлтгэлийн төлөвлөгөө гарган БТСХ-ны даргаар батлуулж, төсөв гаргуулан 7 хоногийн хугацаанд зохион байгууллаа. Сэргэлт бэлтгэл нь Шигшээ багийн тамирчдад бие бялдрын сэргэлт мөн сэтгэл зүйн урам зориг өгсөн үр Дүнтэй бэлтгэл болсон. Бэлтгэлийн хугацаанд өгсөн ачаалал нь тамирчдыг сэргээх, амраах, ББЕХ-г ахиулахад түлхүү чиглэсэн болно



-Ширээний теннисний өсвөрийн тамирчид 2017 оны 07 сарын 01-10-ы өдрүүдэд хүүхдийн Жавхлант зуслан дээр сэргэлтийн бэлтгэлд хамрагдлаа. Бэлтгэлд 10 тамирчид идэвхтэй хамрагдсанаас 1 хүүхэд эмчийн магадлагаагаар буцсан. Эрүүл агаарт дан ганц бэлтгэл сургуулалтаас гадна зуслангийн үйл ажиллагаанд оролцсон нь хүүхдийг амрах, сургуулилтанд оролцох урам зоригыг өгсөн сөйн талтай байлаа.



- Гимнастикийн мэргэжлийн сургалттай 21-р сургуулийн спортын гимнастикийн 10 тамирчин 2017 оны 7 – р сарын 19 -26 ны өдрүүдэд “БАРУУН ЗҮҮН ЭХ” амралт сувиллын газар 7 хоног сэргэлт бэлтгэлд гарав.



Тамирчид тус сувиллын газар амарч алжаалаа тайлахын зэрэгцээ цэвэр агаарт уул усандаа ойртон байгалийн сайхныг ашиглан бэлтгэл сургуулилалтаа хийлээ. Ялангуяа хөлийн түлхэлт гүйлтийн техникийг сайжруулахад онцгой анхаарч уул усныхаа давуу талыг ашиглан бэлтгэл хийхийг зорилоо.

Тамирчдын бэлтгэлд анхаарахаас гадна чөлөөт цаг, амралтын үеэр нь англи хэлний сургалт зохион байгуулж, мөн бусад спортын төрлүүдийн эв дүй оруулж сагсан бөмбөг, хөл бөмбөг, ширээний теннис, волейбол тоглуулах, уралдаан зохиох гэх мэтээр амраав.



**-Тэшүүрийн** шигшээ багийн тамирчид 2017 оны 08-р сарын 04-с 2017 оны 08-р сарын 18-ны өдөр хүртэл Булган аймгийн Бугат сумын нутагт ахмадын амралт сувилалын газарт бэлтгэл цугларалтыг хийж гүйцэтгэв.

Энэхүү ажлын зорилго нь өсвөрийн тамирчдын бэлтгэл сургуулилтын эрчмийг нэмэгдүүлэх, техник, ур чадварыг дээшлүүлэх бизнесийн байгууллагуудтай холбох, тэшүүрийн спортыг сурталчилах, нийгмийн дунд тэшүүрийн спортыг таниулан хөгжүүлэхэд гол зорилго оршино.

Тус цугларалтын 14 хоногийн хоолны төсөвт 1,600,000 төгрөг зарцуулав. Байр, унааны асуудлыг эцэг, эхийн дэмжлэгээр шийдвэрлэсэн болно. 14 хоногийн бэлтгэл цугларалтын хугацаанд тамирчдын бие бялдрын хөгжил, цаашид бэлтгэл хийх ур чадвар өссөн болно.



Цаашид зуны цугларалт бэлтгэлийг тогтмол төсөв мөнгийг шийдвэрлэж



хийлгэснээр тамирчдын ур чадвар өсөж амжилт ахиж байгаа нь жилээс жилд харагдаж байна.



## 2017 онд ХИЙСЭН НЭМЭЛТ АЖИЛ

### “Олимпизм ба бие бялдрын хүмүүжил” сэдэвт болзолт уралдаан

Монголын үндэсний олимпын хорооноос Биеийн тамир, спортын эрчимтэй хөгжлийн төлөө Спортын салбарын төрийн захиогааны байгууллагатай нягт хамтран ажиллах арга хэмжээний хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад олимпын соёл, үнэт зүйл, олимпын боловсрол ба хүмүүжлийг түгээн дэлгэрүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор зохион байгуулж байгаа “Олимпизм ба бие бялдрын хүмүүжил” сэдэвт болзолт уралдааныг 2017 оны 11 сарын 01-ээс 04 сарын 20 хүртлэх хугацаанд Баянзүрх дүүрэгт зохион байгуулах тухай Олимпын зөвлөл, Биеийн тамир спортын хороо, Боловсролын хэлтсийн гурвалсан гэрээг 2017 оны 10 сарын 30-ны өдөр байгууллаа.

Гурвалсан гэрээг зохион байгуулахад Баянзүрх дүүргийн олимпын зөвлөлийн дарга Ч.Төмөрчөдөр, Биеийн тамир спортын хорооны дарга МУГД С.Эрдэнэбат, ахлах мэргэжилтэн Ю.Батсайхан, Боловсролын хэлтсийн дарга, М.Цогзолмаа, ахлах мэргэжилтэн П.Өлзийтөгс, Нийгмийн хөгжлийн хэлтсийн Эрүүл мэнд, нийтийн биеийн тамир хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Болор-Эрдэнэ нар байлцлаа.

Мөн тус болзолт уралдааныг дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудын дунд “Зохион байгуулах хороо”-г цаг хугацаанд нь зохион байгуулахаар тохиролцлоо.



### “Олимпизм ба бие бялдрын хүмүүжил” сэдэвт болзолт уралдаантай холбоотой Засаг даргын захирамж гарлаа

“Олимпизм ба бие бялдрын хүмүүжил” сэдэвт болзолт уралдааныг Баянзүрх дүүрэгт зохион байгуулах тухай Засаг даргын 2017 оны 11 дүгээр сар 06

–ний өдрийн А|367 тоот захирамж гарсаны дагуу өнөөдөр дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудын захирлуудтай тус уралдааныг зохион байгуулах хорооны гишүүн Баянзүрх дүүргийн БТСХ-ны дарга С.Эрдэнэбат, Боловсролын хэлтсийн дарга М.Цогзолмаа, Олимп зөвлөлийн дарга Ч.Төмөрчөдөр, нарийн бичгийн дарга БТСХ-ны ахлах мэргэжилтэн Ю.Батсайхан, боловсролын хэлтсийн ахлах мэргэжилтэн П.Өлзийтөгс нар уулзалт хийлээ.

Уулзалтаар болзолт уралдааны удирдамжыг танилцуулж Олимпизм болон уралдааны ач холбогдлын талаар танилцуулж дүүрэгтээ болон сургууль дээрээ болзолт уралдааныг үр дүнтэй зохион байгуулахаар тохиролцлоо.



Баянзүрх дүүрэгт “Олимпизм ба бие бялдрын хүмүүжил” сэдэвт болзолт уралдааныг 2017 оны 11 дүгээр сарын 01-ээс 2018 оны 04 дүгээр сарын 20-ны хооронд зохион байгуулах ажлын хэсгийг байгууллаа. Уулзалтанд Баянзүрх дүүргийн харъяа улсын болон хувийн 30 сургуулийн захирал оролцлоо.

### **“Олимпизм ба бие бялдрын хүмүүжил” сэдэвт болзолт уралдаан Шавь цогцолбор сургууль дээр**

Олимпизм ба бие бялдрын хүмүүжил” сэдэвт болзолт уралдааныг Баянзүрх дүүрэгт зохион байгуулах тухай Засаг даргын 2017 оны 11 дүгээр сар 06 –ний өдрийн А|367 тоот захирамж гарсаны дагуу дүүргийн Шавь цогцолбор сургууль хөтөлбөр боловсруулж хөтөлбөрийн дагуу 2017 оны 11 сарын 27 өдөр “ Спортын алдартануудтай уулзах уулзалт” зохион байгууллаа.

Уулзалтанд: МҮОХорооны дэд ерөнхийлөгч, 22-р зуны олимпын жү-до бөхийн мөнгөн медальт, ардын багш, гавъяат тамирчин, Монгол улсын начин Ц.Дамидан, МҮОХороон мэргэжилтэн н.Гомбодорж, БЗД-н Олимп зөвлөлийн дарга Ч.Төмөрчөдөр, БЗД-н биеийн тамир спорт хороон мэргэжилтэн О.Түмэнжаргал нар байлаа.



**“Олимпизм ба бие бялдрын хүмүүжил” сэдэвт болзолт  
Уралдаан 97-р сургууль дээр**

Баянзүрх дүүргийн Ерөнхий боловсролын 97-р сургууль дээр очиж ажилтай танилцаж 97-р сургуульд Олимпын кабинеттай болгох талаар Баянзүрх дүүргийн Олимпын зөвлөлийн дарга Ч.Төмөрчөдөр зөвөлгөө өглөө.



**“Олимпизм ба**

**хүмүүжил” сэдэвт болзолт  
Уралдаан 48-р сургууль дээр**

**бие бялдрын**

“Олимпизм ба бие бялдрын хүмүүжил” сэдэвт болзолт уралдаанд Баянзүрх дүүргийн ЕБС-ууд хөтөлбөр гарган ажиллаж байгаа бөгөөд хөтөлбөрийн дагуу 48-р сургууль "Спортын алдартануудаа алдаршуулах" арга хэмжээ зохион байгууллаа. Уулзалт арга хэмжээнд: МҮО Хорооны мэргэжилтэн З.Гомбодорж , БЗД-н Олимп зөвлөлийн дарга Ч.Төмөрчөдөр, БЗД-н биеийн тамир спорт хорооны ахлах мэргэжилтэн Ю.Батсайхан нар байлаа. 48-р сургуулийн хамт олон тус болзолт уралдааны хүрээнд шатрын кабинет тохижуулж сургууль хамт олноороо шатарчин болох уриалга гаргалаа.



**“Олимпизм ба бие бялдрын хүмүүжил” сэдэвт болзолт  
Уралдаан 33, 84, 21-р сургууль дээр**

"Олимпизм ба бие бялдрын хүмүүжил" сэдэвт болзолт уралдаанд Баянзүрх дүүргийн ЕБС-ууд хөтөлбөр гарган ажиллаж байгаа бөгөөд хөтөлбөрийн дагуу 33-р сургууль, 21-р сургууль, 84-р сургууль "Спортын алдартануудаа алдаршуулах" арга хэмжээ зохион байгууллаа. Баянзүрх дүүргийн Олимп зөвлөлөөс Хөвсгөл аймгийн биеийн тамирын багш, дасгалжуулагч нарт Олимп зөвлөл болон Баянзүрх дүүргийн шилдэг багш нарын туршлага судлах арга хэмжээ зохион байгуулсан. Уулзалт арга хэмжээнд: БЗД-н Олимп зөвлөлийн дарга Ч.Төмөрчөдөр, Хөвсгөл аймгаас ирсэн 20 зочид төлөөлөгчид, БЗД-н биеийн тамир спорт хорооны ахлах мэргэжилтэн Ю.Батсайхан нар байлаа. 33-р сургуулийн хамт олон тус болзолт уралдааны хүрээнд "Олимп төв" -ыг шинээр тохижуулж сургууль хамт олноороо уриалга гаргалаа.




## 7. Дүгнэлт

### УРАЛДААН ТЭМЦЭЭНИЙ ТАЛААР

Биеийн тамир спортын хорооны 2017 оны үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд болон БТСХ-ны хийх ажлын календарчилсан төлөвлөгөөнд 4 насны ангиллар нийт 29 уралдаан тэмцээн тусгагдсан байна.

Дүүргийн аварга шалгаруулах тэмцээн 2017 онд өсвөр үеийн 17, залуучууд, оюутны 5, насанд хүрэгчдийн спортын 5, ахмадын 3, нийт 30 тэмцээн явагдсан бөгөөд өсвөрийн 2 тэмцээн нэмж явуулсан. Үүнээс харвал тэмцээн уралдаан зохион байгуулах төлөвлөгөө 100 %-ийн биелэлтэй байна.

Дүүргийн биеийн тамир, спорт хорооноос зохион байгуулсан Баянзүрх дүүргийн аварга шалгаруулах нийт тэмцээн уралдааны 56,6 %-ийг өсвөр үеийн, 16,7 % залуучууд, оюутны, 10 % амхадын, 16,7 % насанд хүрэгчдийн тэмцээн эзэлж




байна.

## НИЙТИЙН БИЕИЙН ТАМИРЫН ТАЛААР

Нийтийн биеийн тамирын төлөвлөгөө гарган байгууллагын даргаар батлуулж жилийн туршид нийслэл дүүргийн арга хэмжээ тэмцээн уралдааныг хуваарийн дагуу зохион байгуулж оролцлоо. Нийтийн биеийн тамирын арга хэмжээнд нийтдээ 733 байгууллагын 35845 ажилтан албан хаагч, иргэд, оюутан сурагчид хамрагдсан байна.

Нийтийн биеийн тамирын арга хэмжээг өмнөх онтой харьцуулан гаргавал:



## ИРГЭДИЙН НААДМЫН ТАЛААР

Нийслэлийн иргэдийн VI наадмыг Баянзүрх дүүрэгт зохион байгуулсан, Нийслэлийн шигшээ тэмцээнд оролцсон тайлангаас болон доорх харьцуулсан графикаас харахад бүс, дүүрэг, нийслэлийн шатанд оролцогчын тоо урьд жилийнхээс бага зэрэг цөөрсөн боловч хамрагдсан хороодын тоо өссөн үзүүлэлт гарчээ.



Баянзүрх дүүргийн Биеийн тамир спортын хорооны даргын төсвийн ерөнхийлөн захирагчтай хийсэн үр дүнгийн гэрээ, гэрээний хавсралт болох байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө, тусгай арга хэмжээний төлөвлөгөө, байгууллагын календарчилсан төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагаа хуваарийн дагуу хэвийн явагдаж 100 % биелэлттэй байна.

Биеийн тамир, спортын хороо нь “**2017-Хариуцлагатай ажилтан**” уриа дэвшүүлэн ажилласан нь албан хаагчдын цаг ашиглалт, ажлын чанарт бодит ахиц гарсныг онцлон тэмдэглэх нь зүйтэй байна.

**БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ХОРОО**